



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 24

Мандалговь

**Э.Энхмэндийг албан тушаалд нэр  
дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар хуралдааны шийдвэр, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын комиссын 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын барилга хот төлөвлөлтийн хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитекторчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Эрдэнийн Энхмэнд 103.2 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.


Хоёр. Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Э.Энхмэндийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

782821059



**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитекторын албан тушаалд нэр дэвшүүлсэн Эрдэнийн Энхмэндийн тухай дүгнэлт**

1. Э.Энхмэнд нь 1990 онд Дундговь аймгийн Өлзийт сумын төвд төрсөн. 30 настай. Эрэгтэй.
2. Боловсролын байдал: Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийг 2009-2014 онд барилгын инженерийн бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн. Иргэний ба үйлдвэрлэлийн барилга мэргэжилтэй.
3. Ажлын туршлага: 2015-2020 онд Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтэст барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 2020 оноос барилга хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитекторын албан тушаалыг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа.
4. Э.Энхмэндийг төрийн захиргааны албанд ажиллаж байгаа ажлын дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитекторын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ